



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

Нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл дараах хаягаар харилцана уу:

Санхүүгийн Аудитын Газрын захирал бөгөөд
Тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг
Утас: 261663
Цахим хаяг:
naranchimegts@audit.gov.mn

Аудитын менежер: Г.Гүнжидмаа
Утас: 261885
Цахим хаяг:
gunjidmaag@audit.gov.mn

Аудитор: Г.Жавхлан
Утас: 261628
Цахим хаяг:
javkhlant@audit.gov.mn

ТАБ-ын хаяг: Засгийн газрын IV байр,
Чингэлтэй дүүрэг, бага тойруу-6,
Улаанбаатар – 46, Монгол улс
Цахим хуудас: www.audit.mn

“Монголиан бизнес рейтинг аудит” ХХК
Ерөнхий захирал Д.Түмэнжаргал
Утас: 70005329
Цахим хаяг:
mbr.audit.llc@gmail.com

УС ЦАГ УУР, ОРЧНЫ СУДАЛГАА, МЭДЭЭЛЛИЙН ХҮРЭЭЛЭНГИЙН 2017 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН

Аудитын тайлан

- Хавсралт 1: Агуулга
- Хавсралт 2: Аудитын гэрчилгээ
- Хавсралт 3: Менежментийн захидал
- Хавсралт 4: Аудит хийсэн санхүүгийн тайлан
- Хавсралт 5: Төсвийн гүйцэтгэлийн тайлан

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

**ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ**

АГУУЛГА

1. Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл
2. Байгууллагын хууль, эрх зүйн орчин
3. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа
4. Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн
5. Материаллаг байдлын түвшин
6. Дотоод хяналт
7. Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар
8. Шилэн дансны мэдээлэл
9. Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар
10. Гол, онцлог гүйлгээний талаарх (тохиромжтой бол) тайлбар
11. Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар:
12. Анхаарал татахуйц бусад чухал асуудал
13. Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд
14. Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл
15. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
16. Зөвлөмж
17. Аудитын гэрчилгээний тохирох загварын талаарх дүгнэлт

Нэг. Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл:

Монгол Улсын “Төрийн аудитын тухай” хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.5, “Төсвийн тухай” хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу “Ус цаг уур, орчны судалгаа, мэдээллийн хүрээлэн”-гийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд /САГ-2018/327/СТА-ТШЗ/ аудит хийлээ.

Аудитыг Төсвийн тухай, Төрийн аудитын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандартын зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

“Ус цаг уур, орчны судалгаа, мэдээллийн хүрээлэн”-гийн 2017 оны санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандарт /УСНББОУС/, түүнд нийцүүлэн гаргасан улсын төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн захирагч санхүүгийн тайлангаа УСНББОУС, түүнд нийцүүлсэн Сангийн сайдын баталсан холбогдох журмууд, байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, програм хангамжийн дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Тухайн байгууллагын санхүүгийн тайлан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС-тай нийцүүлж материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

“Ус цаг уур, орчны судалгаа, мэдээллийн хүрээлэн”-гийн 2017 оны санхүүгийн тайлангийн аудитыг 2018 оны 01 дүгээр сарын 30-ны өдөр анхны уулзалтаа хийж, гэрээт ажлын захидал, аудитын ажилд шаардлагатай материалын жагсаалтыг хүргүүлж аудитыг эхлүүлэн, аудитын төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу 2018 оны 02 дугаар сарын 25-ны өдрийг хүртэлх хугацаанд “Монголиан Бизнес Рейтинг Аудит” ХХК-ийн аудитын баг хэрэгжүүлэв. /ТАБ-СТА-А-9/

“Монголиан Бизнес Рейтинг Аудит” ХХК нь жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитыг 2018 оны 01 дүгээр сарын 25-ны өдрөөс 2018 оны 2 дугаар сарын 23-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2018 оны 2 дугаар сарын 26-ны өдөр Ус цаг уур, орчны судалгаа, мэдээллийн хүрээлэнгийн удирдлагад гардуулна.

Хоёр. Байгууллагын хууль, эрх зүйн орчин:

“Ус цаг уур, орчны судалгаа мэдээллийн хүрээлэн”-ийн төсвийн захирагч нь Монгол Улсын “Төсвийн тухай”, “Төрийн болон орон нутгийн өмчийн тухай”, “Нягтлан бодох бүртгэлийн тухай”, “Байгаль орчныг хамгаалах тухай”, “Ус, цаг уур, орчны хяналт шинжилгээний тухай”, “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай”, “Нийтийн албан нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай”-ийн дансны тухай”, “Нийгмийн даатгалын багц хууль”, “Шинжлэх ухаан, технологийн хууль”, “Хөдөлмөрийн тухай хууль”, “Хувь хүний орлогын албан татварын хууль”, “Иргэдээс Төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай” хуулиудын хүрээнд үйл ажиллагаа эрхэлж байна. Тайлант онд тухайн байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг гол хууль, тогтоомж, түүнд нийцүүлэн гарсан журам, зааварт өөрчлөлт ороогүй байна.

Гурав. Байгууллагын зорилго, чиг үүрэг, үйл ажиллагаа:

Зорилго: Эрдэм шинжилгээ, судалгаанд суурилсан ус, цаг уур, уур амьсгал, байгаль орчны судалгааны болон бодит, урьдчилсан мэдээ, мэдээллээр үйлчлэхэд оршино.

Эрхэм зорилгодоо хүрэхийн тулд тайлант хугацаанд дараах чиг үүргийг хэрэгжүүлэн ажилласан байна. Үүнд:

- Ус цаг уур, уур амьсгал, байгаль орчны бодит болон ирээдүйн төлөв байдлын тухай мэдээллээр төр засаг, нийгэм-эдийн засаг, хүн амын эрэлт хэрэгцээг хангах,
- Ус, цаг уур, орчны хяналт шинжилгээний улсын сүлжээний арга зүй, технологийг боловсруулах, үйлдвэрлэлийн туршилт хийх,
- Ус цаг уур, уур амьсгал, байгаль орчин, тандан судалгаа, мэдээллийн технологийн чиглэлээр судалгаа хийх, үр дүнг үйлдвэрлэлд нэвтрүүлэх, технологи, төсөл, хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлэх, оролцох, мэргэжлийн дүгнэлт, зөвлөмж, үнэлгээ гаргах,
- Дэлхийн ажиглалтын бүлэг, Дэлхийн цаг уурын байгууллага болон бусад улс орон, олон улсын холбогдох хөтөлбөр, гэрээ, хэлэлцээртэй үйл ажиллагаа уялдуулах,
- Дэлхийн цаг уурын байгууллагын мэдээллийн сүлжээн дэх цаг уурын холбооны үндэсний төвийн үүргийг гүйцэтгэх,
- Зайнаас тандан судлах үндэсний төвийн үүргийг гүйцэтгэх,
- Байгаль орчны мэдээллийн төвийн үүргийг гүйцэтгэж, мэдээллийн сангийн өдөр тутмын үйл ажиллагааг эрхлэх,

Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1-д “Төсвийн байгууллага нь түүний үйл ажиллагааг үр ашигтай удирдлагаар хангаж, ажлын үр дүнг хариуцах үүрэг бүхий төсвийн шууд захирагчтай байна” гэж заасан байна.

Төсвийн тухай хуулийн 16.5-д заасан бүрэн эрхийн дагуу тус байгууллагын төсвийн шууд захирагч нь батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдаж, зарцуулалтад нь хяналт тавьж ажилласан байна. Тус байгууллагын 2017 оны төсвийг БОАЖЯ-ны Төрийн сангийн газраас олгож байна.

“Ус цаг уур, орчны судалгаа, мэдээллийн хүрээлэн”-гийн үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд ТАБ-СТА-А-1 маягтад тодорхой тусгасан.

Дөрөв. Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн:

Аудитыг гүйцэтгэхдээ Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Сангийн сайдын 2006 оны 388-р тушаалаар батлагдсан “Төсөвт байгууллагын санхүүгийн тайланг бэлтгэх заавар”, бусад холбогдох заавар журмуудыг шалгуур болгон, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2014 оны 203 дугаар тушаалаар баталсан “Санхүүгийн тайлангийн аудитын журам”, бусад гарын авлагын дагуу гүйцэтгэв.

Аудитаар “Ус цаг уур, орчны судалгаа, мэдээллийн хүрээлэн”-ийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд дүгнэлт өгөхийн тулд төсвийн захирагчийн бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахаар уламжлалт болон хяналтын эрсдэлийг тогтоон тухайн байгууллагын зүгээс тавьж буй дотоод хяналтыг үнэлж баримтжууллаа. /ТАБ-СТА-А-5/

Санхүүгийн тайланг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, зарим гүйлгээ ихтэй томоохон дансад түүвэрчилсэн байдлаар аудитын нарийвчилсан горим, сорил 22-ыг гүйцэтгэв. /ТАБ-СТА-В-3/

Тухайн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, нягтлан бодох бүртгэлийн мэдээллийн системтэй танилцахад Санхүүгийн тооцолох төвийн Acolous 4,01 программ ашигладаг, Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын сайдын /тухайн үеийн нэрээр/ 2016 оны А/58 дугаар тушаалаар баталсан “Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”-ийг нягтлан бодох бүртгэлдээ мөрдөн ажиллаж байна. Энэхүү бүртгэлийн бодлогын баримт бичиг нь УСНББОУС-тай нийцсэн байна.

“Ус цаг уур, орчны судалгаа мэдээллийн хүрээлэн”-гийн үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа компьютерийн системийн үйл ажиллагаатай асуулга явуулах аргаар танилцан түүний нарийн төвөгтэй байдлын үнэлгээг хийхэд бага буюу мэдээллийн технологийн мэргэжилтэнг оролцуулах шаардлагагүй гэсэн үнэлгээ өгч, аудитыг шууд гүйцэтгэлээ. /ТАБ-СТА-В-2/

“Ус цаг уур, орчны судалгаа мэдээллийн хүрээлэн” нь санхүүгийн үйл ажиллагааг бүртгэх, хянах, боловсруулах үйл ажиллагааг Санхүүгийн тооцолох төвийн Acolous 4,01 програмаар боловсруулан санхүүгийн тайлан бэлтгэх аргачлалын дагуу санхүүгийн тайланг гаргасан байна

Материаллаг байдлын түвшин:

“Ус цаг уур, орчны судалгаа мэдээллийн хүрээлэн”-гийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайланд тусгагдсан тоон үзүүлэлтүүдээр материаллагийн түвшинд нөлөөлөх хүчин зүйлсийн нөлөөллийг урьдчилан үнэлж, 2017 оны төсвийн нийт зардал 2,150.1 сая төгрөгийг материаллаг байдлын суурь болгон түүний 2 хувиар тооцож, материаллаг байдлын түвшинг 43.0 сая төгрөгөөр урьдчилан тогтоов. Гүйцэтгэлээр материаллаг байдлыг дахин хянаж, материаллаг байдлын түвшинг өөрчлөх шаардлагагүй гэж үзлээ.

Тав. Дотоод хяналт:

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм. Тус байгууллагын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үед “бага” гэж тооцсон ба дахин хянахад дотоод хяналт хэвийн байна.

Зургаа. Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар:


“Ус цаг уур, орчны судалгаа мэдээллийн хүрээлэн”-ийн 2017 оны батлагдсан төсвийг сар, улирлын хуваарийн дагуу салбарын яамны Төрийн сангийн харилцах дансаар дамжуулан санхүүжүүлсэн байна. Төрийн сангаас тус байгууллагын төсвийн хүрээний мэдэгдлийг боловсруулах, төсвийн санхүүжилтийн гүйцэтгэлийг хангах, төсвийг зардлын төрөл зүйлээр хуваарилан баталж, гүйцэтгэлд хяналт тавин ажилласан байна.

Тус байгууллагын 2017 оны батлагдсан төсөв 1,098,629.6 мянган төгрөг байна. Төсвийн тодотголоор 71,843.9 мянган төгрөгийн санхүүжилт нэмэгдэж батлагдсан төсөв нийт 1,170,473.5 мянган төгрөг болсон байна.

Санхүүжилтийн эх үүсвэрийн хувьд улсын төсвийн санхүүжилт 1,170,473.5 мянган төгрөг, төсөвт байгууллагын үндсэн үйл ажиллагааны 1,650.0 мянган төгрөгийн орлого олох төлөвлөгөөтэй байна.

Санхүүжилтийн орлогын гүйцэтгэлийн хувьд улсын төсвөөс 1,156,568.2 мянган төгрөгийн урсал санхүүжилт авч, үндсэн болон туслах үйл ажиллагааны орлогыг 296.4 мянган төгрөгөөр давуулан 1,946.4 мянган төгрөгийн орлого олсон байна.

Төсвийн зардлын хувьд бараа үйлчилгээний зардалд 1,100,279.6 мянган төгрөг, урсгал шилжүүлэгт 71,843.9 мянган төгрөгийн төсөв батлагдаж, гүйцэтгэлээр бараа ажил үйлчилгээний зардалд 1,099,575.1 мянган төгрөг, урсгал шилжүүлэгийн зардалд 56,993.2



мянган төгрөгийг зарцуулан, батлагдсан төсвийг 15,555.3 мянган төгрөгөөр хэмнэсэн байна. Оны эцэст 4,921.7 мянган төгрөгийг улсын төсөвт татан төвлөрүүлсэн байна.

Тус байгууллага гадаадын 11, дотоодын 3, нийт 14 байгууллага, нэгжтэй хамтарсан судалгааны ажилд 14 төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлж, нийт 920,448.3 мянган төгрөгийн нэмэлт санхүүжилтийг авч, гүйцэтгэлээр 908,448.3 мянган төгрөгийн зарцуулалт гарч, 12,000.0 мянган төгрөгийг төсөвт татан төвлүүлснийг авлагаар бүртгэж тайлагнасан байна.

Өмнөх оноос богино хугацаатай авлага 143,662.2 мянган төгрөгөөр, богино хугацаат өр төлбөр 7,270.9 мянган төгрөгөөр тус тус буурсан байна.

Долоо. Шилэн дансны мэдээлэл:

Шилэн дансны тухай хуулийн дагуу төсвийн болон улс, орон нутгийн өмчийн хөрөнгийг үр ашигтай захиран зарцуулах зорилгоор төсвийн удирдлагын шийдвэр, үйл ажиллагаа ил тод, нээлттэй, ойлгомжтой байх, түүнд олон нийт хяналт тавих тогтолцоог хуулийн дагуу хангасан талаар шилэн дансны вебсайт хуудсанд байршуулсан мэдээллийг шалгаж үзэхэд орлого, зардал, удирдлагын шийдвэр, санхүүжилт, тендер шалгаруулалт, худалдан авалт зэрэг ажил гүйлгээний талаарх мэдээллийг shilendans.gov.mn сайтад байршуулж олон нийтэд толилуулж байна. Үүнд: 2017 онд нийт 125 мэдээлэл байршуулснаас 5,000.0 мянган төгрөгөөс дээш зардлын гүйлгээний 36 мэдээллийг байршуулсан байна. Харин 5,000.0 мянган төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг зэрэг мэдээллийг загварын дагуу бүрэн оруулаагүй байна.

Найм. Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар:


Аудитын төлөвлөгөөний дагуу аудитын 23 эрсдлийг тогтоож, батламж мэдэгдлүүдийн хүрээнд данс бүрээр нийт 22 нарийвчилсан горим, сорил гүйцэтгэв.

Урьдчилж төлсөн зардал 15,267.0 мянган төгрөгийг бараа үйлчилгээний бусад зардлаар, мөнгөн хөрөнгөнд 117.8 мянган төгрөгийн анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэсэн, байгууллагын ажилтанууд олгосон 17,550.0 мянган төгрөгийн ажил гүйцэтгэх гэрээт ажлын хөлснөөс 1,719.9 мянган төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэл ногдуулаагүй зэрэг зөрчлүүд илэрсэн.

Ес. Гол, онцлог гүйлгээний талаарх (тохиромжтой бол) тайлбар:

“Ус цаг уур, орчны судалгаа, мэдээллийн хүрээлэн”-гийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэдгийг, түүнийг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, аудитын явцад санхүүгийн тайланд нөлөөлөхүйц хэмжээний мөнгөн хөрөнгө, орлого санхүүжилт, үндсэн хөрөнгө, хөрөнгө оруулалт, худалдан авалт (бараа материал), өр төлбөр, төсөвт байгууллагын ажил үйлчилгээний орлого, бараа үйлчилгээний урсгал зардал зэрэг дансны ажил гүйлгээ, үлдэгдэл, тооцооллуудыг түүвэрчлэн нарийвчилсан горим, сорилын аргаар шалгалаа. /ТАБ-СТА-В-3/

Эдгээр шалгасан нарийвчилсан сорил нь тус байгууллагын нийт орлогын 100 хувь, мөнгөн хөрөнгийн 100 хувь, авлага, өр төлбөрийн 100 хувь, зардалын 82 хувийг тус тус эзэлж байна.



Арав. Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар:

Санхүүгийн тайлангийн аудитаар хөндөгдсөн гол асуудлуудыг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Аудитаар дараах алдаа, зөрчил илэрсэн байна. Үүнд:

1. Жижиг мөнгөн сангийн орлого, зарцуулалт, үлдэгдэлд хийсэн түүврийн сорилоор анхан шатны баримтын бүрдэл дутуу, төсвийн зарцуулалтын баримтын бүрдлийг хангаагүй 117.8 мянган төгрөгийн гүйлгээг бүртгэсэн зөрчил илэрч байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно” гэж заасантай нийцээгүй байна.

Шийдвэрлэсэн: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7 дахь заалтыг хэрэгжүүлж ажиллах талаар аудитын зөвлөмж хүргүүлэх.

2. “Гангийн мониторингийн систем дээр дүн шинжилгээ хийж, хэрэглэгчийн талаас зөвлөмж бичих” зөвлөх үйлчилгээний гүйцэтгэгч шалгаруулах тендер зарлаж, тендерийн үр дүнгээр иргэн Д.Ичинхорлоотой 9,900 ам.доллар үнийн дүнтэй, 2018 оны 4 дүгээр сарын 30-нд дуусах ажлын гэрээ байгуулсан байна. Гэрээнд заасны дагуу 2017 оны 12 дугаар сарын 22-нд урьдчилгаа 15,267.0 мянган төгрөг шилжүүлж, бараа үйлчилгээний бусад зардлаар бүртгэж тайлагнасан байна.

Энэ нь УСНББОУС 1, 2, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-д “Холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах”, нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн 4.2.2-д “Урьдчилгаа төлбөр болон дараа тайлангийн тооцоог харилцагч бүрээр данс нээж, урьдчилж төлсөн төлбөр зардлаар бүртгэж тайлагнах” гэж заасантай нийцээгүй байна.

Шийдвэрлэсэн: Санхүүгийн байдлын тайланд залруулах бичилт хийж, алдааг аудитын явцад залруулав.

3. Тайлант хугацаанд “Ногоон алт-Малын эрүүл мэнд” төслийн хүрээнд “Монгол орны бэлчээрийн төлөв байдлын үндэсний тайлан гаргах” ажлаар тус байгууллагын 11 ажилтантай ажил гүйцэтгэх гэрээ байгуулж 17,550.0 мянган төгрөгийн гэрээт ажлын хөлс олгосноос 1,719.9 мянган төгрөгийн НДШ ногдуулаагүй байна.

Энэ нь “Нийгмийн даатгалын тухай” хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2-д “Нийгмийн даатгалд дор дурьдсан ажилтан албан журмаар даатгуулна”, 4.2.1-д “өмчийн бүх хэвшлийн аж ахуйн нэгж, байгууллага, төрийн бус, шашны болон бусад байгууллага, иргэнтэй байгуулсан хөдөлмөрийн гэрээ болон Иргэний хуулийн 343, 359 дүгээр зүйлд заасан гэрээний дагуу ажиллаж байгаа Монгол Улсын иргэн, гадаадын иргэн, харьяалалгүй хүн”, “Хөдөлмөрийн тухай” хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1-д “... Байнгын ажлын байранд хөдөлмөрийн гэрээнээс бусад төрлийн гэрээ байгуулахыг хориглоно” гэж заасантай нийцээгүй байна.

Шийдвэрлэсэн: 1,719.9 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоох, 17,550.0 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага өгөх

4. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг түүвэрлэн шалгаж үзэхэд 5,000.0 мянган төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг зэрэг мэдээллийг зарварын дагуу бүрэн оруулаагүй байна.

Шийдвэрлэсэн: Шилэн дансны тухай хуульд заасан мэдээллийг бүрэн мэдээлж байх талаар аудитын зөвлөмж хүргүүлэх.

Арван нэг. Залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар:

Ус цаг уур, орчны, судалгаа мэдээллийн хүрээлэнгийн санхүүгийн тайланд залруулаагүй алдаа, зөрчил гараагүй болно.

Арван хоёр. Анхаарал татахуйц бусад чухал асуудал:

Тайлант онд “Ус цаг уур, орчны судалгаа мэдээллийн хүрээлэн” нь гадаадын 11, дотоодын 3, нийт 14 байгууллага, нэгжтэй хамтарсан судалгааны ажлын 14 төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлж, нийт 920,448.3 мянган төгрөгийн төслийн санхүүжилт авч эрдэм шинжилгээ, судалгааны ажлуудыг хийж гүйцэтгэсэн байна.

Арван гурав. Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд:

“Ус цаг уур, орчны судалгаа, мэдээллийн хүрээлэн”-гийн 2017 оны жилийн санхүүгийн тайланд залруулагдаагүй алдаа гараагүй болно.

Арван дөрөв. Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл:

Тус байгууллагын төсвийн 2017 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 34,654.7 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрч, 15,267.0 мянган төгрөгийн алдааг аудитын явцад залруулж, 117.8 мянган төгрөгийн зөрчилд зөвлөмж, 1,719.9 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт, 17,550.0 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлэх.

Арван тав. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт:

“Ус цаг уур, орчны судалгаа, мэдээллийн хүрээлэн”-гийн 2016 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар 1 зөвлөмж хүргүүлсэн байна. Зөвлөмжийн биелэлт 100 хувьтай байна.

Арван зургаа. Зөвлөмж

Зөвлөмж 1: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно” гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллах.

Зөвлөмж 2: Шилэн дансны тухай хуульд заасан мэдээллийг иж бүрэн мэдээлж, байршуулах.

Арван долоо. Аудитын гэрчилгээний тохирох загварын талаарх дүгнэлт

Зөрчилгүй дүгнэлт

“Ус цаг уур, орчны судалгаа, мэдээллийн хүрээлэн”-гийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн байна.


ХЯНАСАН:

ХЯНАСАН ЕРӨНХИЙ ЗАХИРАЛ

БЭЛТГЭСЭН:

АУДИТОР

АУДИТОРЫН ТУСЛАХ



/Д. ТҮМЭНЖАРГАЛ/

/Ц. АЛТАНХУЯГ/

/Ө.РАГЧАА/

2018.02.20



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

Нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл дараах
хаягаар харилцана уу:

Санхүүгийн аудитын газрын
захирал бөгөөд тэргүүлэх аудитор:
Ц.Наранчимэг
Утас: 261663

Аудитын менежер: Г.Гүнжидмаа
Утас: 261885
Цахим хаяг:
gunjidmaag@audit.gov.mn

Аудитор: Г.Жавхлан
Утас: 261628
Цахим хаяг:
javkhlang@audit.gov.mn

ТАБ-ын хаяг: Засгийн газрын IV байр,
Чингэлтэй дүүрэг, бага тойруу-6,
Улаанбаатар – 46, Монгол улс
Цахим хуудас: www.audit.mn

“Монголиан бизнес рейтинг аудит” ХХК
Ерөнхий захирал Д.Түмэнжаргал
Утас: 70005329
Цахим хаяг:
mbr.audit.llc@gmail.com

2018 оны 2 дугаар сар

УС ЦАГ УУР, ОРЧНЫ СУДАЛГАА,
МЭДЭЭЛЛИЙН ХҮРЭЭЛЭНГИЙН
2017 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН
САНХҮҮГИЙН ТАЙЛАН

Менежментийн захидал

Тэргүүлэх ач холбогдол № 1

Асуудал 1 Мөнгөн хөрөнгө

Тэргүүлэх ач холбогдол № 2

Асуудал 2 Шилэн дансны мэдээлэл

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

**ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ**

Менежментийн захидал

Монгол Улсын “Төрийн аудитын тухай” хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.5, “Төсвийн тухай” хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1 дэх заалтын дагуу, ҮАГ-ын бүрэн эрхийн хүрээнд Монгол Улсын Ерөнхий Аудитортай 2018 оны 1 дүгээр сарын 25-нд байгуулсан “Аудитын ажил гүйцэтгэх” ҮАГ/АА2018-71 дугаар бүхий гэрээний дагуу “Ус цаг уур, орчны судалгаа, мэдээллийн хүрээлэн”-гийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бид аудитын явцад илрүүлсэн зөрчил, үйлчлүүлэгч байгууллагад байж болзошгүй хяналтын сул тал, цаашид хяналтыг сайжруулах шаардлагатай болох зөвлөмжийг Менежментийн захидлаар хүргүүлдэг.

Энэхүү Менежментийн захидлын агуулга нь Аудитын олон улсын стандартад тулгуурлан бидний гүйцэтгэсэн аудитын горим, ажлын үр дүнгээс үүдэн гардаг.

Аудитын төлөвлөлтийн явцад үйлчлүүлэгч байгууллагын удирдлагын хяналтанд үнэлгээ өгөх, түүнээс гарч болох эрсдлийг тодорхойлж бодит эрсдэл /алдаа, зөрчил/-ийг илрүүлэх аудитын горимыг гүйцэтгэдэг.

Аудитын горим нь танай байгууллагын санхүүгийн тайлангийн талаар санал дүгнэлт гаргахад зориулагдсан. Энэ нь танай байгууллагын хэрэгжүүлдэг нягтлан бодох бүртгэлийн бодлого, тогтолцоо, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянах бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын зөвлөмжүүд маань аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний ойлголтыг тусгасан болно. Эдгээр зөвлөмжүүд нь та бүхний бүртгэл, тайлагнал, хяналтын үйл ажиллагааг сайжруулах зорилготой бөгөөд тухайн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Аудитын явцад шаардлагатай баримт материалыг цаг хугацаандаа гаргаж өгч, биднийг мэдээллээр хангаж байсныг сайшаан тэмдэглэж байна.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан танай байгууллагын удирдлага болон ажилтнуудад талархал илэрхийлье.



ҮАГ-ын Ажиглалт

Жижиг мөнгөн сангийн орлого, зарцуулалт, үлдэгдэлд хийсэн түүврийн сорилоор анхан шатны баримтын бүрдэл дутуу, төсвийн зарцуулалтын баримтын бүрдлийг хангаагүй 117.8 мянган төгрөгийн зөрчил илэрч байна.

Эрсдэл:

1. Санхүүгийн тайлан тэнцэл буруу гарах
2. Удирдлага болон шийдвэр гаргагчдыг буруу мэдээллээр хангах
3. Хууль тогтоомж, журам, заавар зөрчигдөх

ҮАГ-ын Зөвлөмж

1. Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно” гэж заасныг хэрэгжүүлж ажиллах.

2018 оны 7 дугаар сарын 25-ны дотор хэрэгжүүлж, хариу өгөх.

Үйлчлүүлэгчийн хариу**01**

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

**ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ**

ҮАГ-ын Ажиглалт

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг түүвэрлэн шалгаж үзэхэд 5,000.0 мянган төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг зэрэг мэдээллийг загварын дагуу бүрэн оруулаагүй байна.

ҮАГ-ын Зөвлөмж

1. Шилэн дансны тухай хуульд заасан мэдээллийг иж бүрэн мэдээлж байршуулах.

2018 оны 7 дугаар сарын 25-ны дотор хэрэгжүүлж хариу өгөх


Эрсдэл:

1. Шилэн дансны тухай хууль тогтоомж хэрэгжихгүй байх.
2. Хэрэглэгч бодиттой мэдээллээр хангагдахгүй байх

Үйлчлүүлэгчийн хариу

**УС ЦАГ УУР, ОРЧНЫ СУДАЛГАА МЭДЭЭЛЛИЙН ХҮРЭЭЛЭН
АУДИТ ХИЙГДСЭН 2017 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН
САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН
2017 оны 12-р сарын 31-нээр дуусвар болсон тайлант жил**

		/төгрөг/	
Дансны код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
31	МӨНГӨ БА ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГӨ	378.10	-
312	Банкинд байгаа бэлэн мөнгө /төгрөгөөр/	378.10	-
33	АВЛАГА	155,662,268.18	12,000,000.00
33300	Татаас санхүүжилтийн авлага	155,070,829.98	12,000,000.00
3352	Хувь хүмүүсээс авах авлага	591,438.20	-
34	УРЬДЧИЛЖ ТӨЛСӨН ТӨЛБӨР		15,267,084.00
34600	Урьдчилж гарсан зардал		15,267,084.00
35	БАРАА МАТЕРИАЛ	152,596,169.29	150,888,042.77
35410	Бичиг хэрэг	56,148,637.00	55,299,774.00
35420	Аж ахуйн материал	18,903,920.20	18,252,164.74
354	Хангамжийн материал	76,094,311.00	76,114,202.94
35440	Түлш шатах тослох материал	192,801.09	1.09
35450	Барилгын засварын материал		1,221,900.00
	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	308,258,815.57	178,155,126.77
	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГӨ	477,661,121.47	390,354,440.07
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	477,661,121.47	390,354,440.07
392	Биет хөрөнгө	472,143,694.63	389,908,373.37
39201	Барилга байгууламж	440,795,520.00	440,795,520.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(277,333,847.99)	(284,680,439.99)
39203	Авто тээврийн хэрэгсэл	66,575,250.00	66,575,250.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(63,719,453.97)	(64,711,237.48)
39205	Машин, тоног төхөөрөмж	1,319,356,695.33	1,102,753,636.49
39206	Хуримтлагдсан элэгдэл	(1,068,976,097.32)	(917,756,793.84)
39207	Тавилга, эд хогшил	132,741,320.94	126,887,667.01
39208	Хуримтлагдсан элэгдэл	(101,277,642.84)	(99,786,626.78)
39209	Зам гүүрийн барилга байгууламж	23,293,802.00	23,218,802.00
39210	Хуримтлагдсан элэгдэл	(16,417,454.73)	(20,468,535.22)
39214	Бусад үндсэн хөрөнгө	1,234,305.63	1,209,833.60
39217	Номын фонд	15,871,297.58	15,871,297.58
393	Биет бус хөрөнгө	5,517,426.84	446,066.70
39301	Программ хангамж	179,548,099.22	165,999,151.22
39302	Хасагдуулга	(174,030,672.38)	(165,553,084.52)
	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	477,661,121.47	390,354,440.07
	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	785,919,937.04	568,509,566.84
413	Өглөг	7,270,944.10	-
4131	Ажиллагчидтай холбогдсон өглөг	845,569.10	-
41361	Байгууллагад төлөх өглөг	5,412,475.00	-
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	1,012,900.00	-
	БОГИНО ХУГАЦААТ ӨР, ТӨЛБӨРИЙН ДҮН	7,270,944.10	-
5101	Засгийн газрын хувь оролцоо	778,648,992.94	568,509,566.84
5103	Хуримтлагдсан үр дүн	778,648,992.94	568,509,566.84
51210	Өмнөх үеийн үр дүн	778,648,992.94	778,648,992.94
51220	Тайлант үеийн үр дүн		(210,139,426.10)
	ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ ӨМЧИЙН ДҮН	778,648,992.94	568,509,566.84
	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ ӨМЧИЙН ДҮН	785,919,937.04	568,509,566.84



УС ЦАГ УУР, ОРЧНЫ СУДАЛГАА МЭДЭЭЛЛИЙН ХҮРЭЭЛЭН
АУДИТ ХИЙГДСЭН 2017 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН
САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН
 2017 оны 12-р сарын 31-нээр дуусвар болсон тайлант жил

/төгрөг/

Дансны код	ҮЗҮҮЛЭЛТ	Өмнөх он	Тайлант он
	1	3	4
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГО	1,955,257,873.50	1,959,118,085.36
	ТАТААС, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,903,108,955.40	1,919,998,870.26
1310	Улсын төсвөөс	1,903,108,955.40	1,919,998,870.26
131001	Урсгал	1,413,974,600.00	1,154,621,396.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан	0.00	707,897,474.26
131104	Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан	489,134,355.40	1,500,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд	0.00	55,980,000.00
	Бараа үйлчилгээний орлого	52,148,918.10	39,119,208.30
1200042	Үндсэн бус үйл ажиллагааны орлого	12,798,320.10	1,441,779.00
1200041	Төсөвт байгууллагын ажил үйлчилгээний орлого	0.00	1,355,000.00
1200045	Үнэ төлбөргүй орлого	39,350,598.00	36,322,429.30
	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	0.00	6.80
120002	Хүүгийн орлого	0.00	6.80
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ҮР ДҮН (1)	1,955,257,873.50	1,959,118,085.36
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ	1,934,555,565.30	2,150,134,376.70
	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,889,815,789.70	2,093,141,218.50
	АЖИЛЛАГЧИДТАЙ ХОЛБООТОЙ ЗАРДАЛ	1,437,650,271.40	1,572,640,970.00
2101	Цалин, хөлс ба нэмэгдэл урамшил	1,294,272,057.40	1,419,068,709.20
	Цалин	1,294,272,057.40	1,419,068,709.20
2102	Нийгмийн хамгааллын шимтгэл	143,378,214.00	153,572,260.80
210201	Тэтгэвэр тэтгэмжийн шимтгэл	92,472,467.10	94,415,409.18
210202	Тэтгэмжийн шимтгэлийн даатгал	13,051,535.20	26,203,374.04
210203	ҮОМШ өвчний даатгал	10,898,227.80	9,428,137.31
210204	Ажилгүйдлийн даатгал	5,391,196.20	4,705,067.65
210205	Эрүүл мэндийн даатгалын шимтгэл	21,564,787.70	18,820,272.62
	Бараа үйлчилгээний урсгал зардал	464,892,611.90	525,421,928.70
	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	93,824,546.00	2,040,601.00
210301	Гэрэл цахилгааны зардал	93,824,546.00	2,040,601.00
	Хангамжийн материалын зардал	30,092,729.80	64,524,910.66
210401	Бичиг хэргийн материал	14,533,343.00	25,915,201.30
210402	Тээвэр, шатахууны зардал	5,743,612.40	20,700,184.90
210403	Шуудан холбооны зардал	7,897,983.40	7,525,309.00
210406	Бага үнэтэй түргэн элэгдэх	1,917,791.00	10,374,215.46
	Эд хогшил урсгал засварын зардал	10,901,700.00	82,106,358.60
210601	Багаж хэрэгсэл	403,100.00	28,936,908.06
210604	Урсгал засварын зардал	10,498,600.00	53,169,450.00




	Томилолт, зочны зардал	42,009,919.00	92,912,155.24
210702	Дотоод томилолтын зардал	40,810,019.00	55,091,635.00
210701	Гадаад томилолтын зардал	1,199,900.00	37,403,774.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	0.00	416,746.24
	Бусдаар гүйцэтгүүлэх ажил үйлчилгээний зардал	128,647,252.10	5,857,160.00
210801	Бусдаар гүйцэтгүүлэх ажил үйлчилгээний зардал	123,889,547.10	2,339,560.00
210802	Аудит, баталгаажуулалт зэрэглэл тогтоох зардал	1,650,000.00	1,633,500.00
210803	Даатгалын үйлчилгээний төлбөр	1,281,400.00	1,260,000.00
210804	Тээврийн хэрэгсэлийн татвар	0.00	251,500.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	20,000.00	19,800.00
210807	Газрын төлбөр	356,400.00	352,800.00
210808	Банк санхүүгийн байгууллагын үйлчилгээний	1,449,905.00	-
	Бараа үйлчилгээний бусад зардал	146,679,371.40	273,069,063.54
220103	Бараа үйлчилгээний бусад зардал	0.00	150,936,776.90
210903	Элэгдлийн зардал	146,679,371.40	122,132,286.64
	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	44,739,775.60	56,993,158.20
	Бусад урсгал шилжүүлэг	32,012,682.00	52,071,478.00
213207	Нэг удаагийн буцалтгүй тусламж	28,098,682.00	25,399,380.00
213209	Нэг удаагийн тэтгэмж урамшуулал	3,914,000.00	26,672,098.00
	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	12,727,093.60	4,921,680.20
213303	Төвлөрүүлэх шилжүүлэх зардал	12,727,093.60	4,921,680.20
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН	20,702,308.20	(191,016,291.34)
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРЛАГЫН ДҮН (5)	0.00	19,123,134.76
225001	Үндсэн хөрөнгө худалсаны гарз	0.00	19,123,134.76
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН	20,702,308.20	(19,123,134.76)
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН	20,702,308.20	(210,139,426.10)

УС ЦАГ УУР, ОРЧНЫ СУДАЛГАА МЭДЭЭЛЛИЙН ХҮРЭЭЛЭН
АУДИТ ХИЙГДСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН
 2017 оны 12-р сарын 31-нээр дуусвар болсон тайлант жил

/төгрөг/

Дансны код	ҮЗҮҮЛЭЛТ	Өмнөх он	Аудитласан
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	2,001,634,148.60	2,091,788,613.24
	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	-	6.80
	Нийтлэг татварын бус орлого	10,968,029.10	1,946,445.00
20002	Хүүгийн орлого	-	6.80
	Төсөвт байгууллагын өөрийн орлого	10,968,029.10	1,946,445.00
120041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	10,968,029.10	1,946,438.20
	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,990,666,119.50	2,091,788,613.24
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,413,974,600.00	1,154,621,396.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,413,974,600.00	1,154,621,396.00
	Нэмэлт санхүүжилтийн орлого	576,691,519.50	920,448,304.24
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан	483,984,355.40	862,968,304.24
131104	Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан	3,500,000.00	1,500,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд	89,207,164.10	55,980,000.00
	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	-	14,772,468.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	-	14,772,468.00
	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (II)	1,964,034,770.40	2,050,519,751.34
	УРСГАЛ ЗАРДАЛ	1,964,034,770.40	2,050,519,751.34
	БАРАА АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,768,138,164.90	1,966,754,125.14
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,293,684,475.30	1,420,558,326.00
210101	Цалин	1,243,088,475.30	1,274,364,726.00
210102	Цалингийн тусгай нэмэгдлүүд	-	107,369,800.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	50,596,000.00	38,823,800.00
2102	Ажил олгочоос нийтийн даатгалд төлөх шимтгэл	140,346,065.20	151,314,934.00
210201	Тэтгэвэрийн даатгал	97,448,972.20	119,098,230.00
210202	Тэтгэмжийн даатгал	8,579,417.00	6,443,343.00
210203	ҮОМШ өвчний даатгал	10,724,264.00	8,054,164.00
210204	Ажилгүйдлийн даатгал	2,144,849.00	1,610,833.00
210205	Эрүүл мэндийн даатгалын шимтгэл	21,448,563.00	16,108,364.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	101,326,669.00	2,990,601.00
210301	Гэрэл цахилгааны зардал	101,326,669.00	2,990,601.00
220103	Хангамж, бараа материалын зардал	21,278,136.40	57,330,682.90
210401	Бичиг хэргийн материал	4,321,874.00	18,202,310.00
210402	Тээвэр, шатахууны зардал	3,241,500.00	23,402,384.90
210403	Шуудан холбооны зардал	7,897,983.40	7,525,309.00
210406	Бага үнэтэй түргэн элэгдэх	2,942,783.00	11,260,679.00
	Нормативт зардал	577,000.00	570,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	577,000.00	570,000.00
	Эд хогшил, урсгал засварын зардал	25,048,257.00	63,051,965.00
210601	Багаж хэрэгсэл	19,359,455.00	15,982,655.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл	128,400.00	126,000.00
210604	Урсгал засварын зардал	5,560,402.00	46,943,310.00



	Томилолт, зочны зардал	41,427,788.00	92,342,087.24
210702	Дотоод томилолтын зардал	40,227,888.00	54,521,567.00
210701	Гадаар томилолт	1,199,900.00	37,403,774.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	-	416,746.24
	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр	144,451,774.00	5,941,160.00
210801	Бусдаар гүйцэтгүүлэх ажил үйлчилгээний хөлс	139,314,049.00	2,423,560.00
210802	Аудит, баталгаажуулалт зэрэглэл тогтоох зардал	1,650,000.00	1,633,500.00
210803	Даатгалын үйлчилгээ	1,281,400.00	1,260,000.00
210804	Тээврийн хэрэгсэлийн татвар	245,920.00	251,500.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	20,000.00	19,800.00
210807	Газрын төлбөр	356,400.00	352,800.00
210808	Банк санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	1,584,005.00	-
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	172,594,369.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	172,594,369.00
	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	195,896,605.50	83,765,626.20
	Бусад урсгал шилжүүлэг	28,098,682.00	66,843,946.00
213209	Нэг удаагийн тэтгэмж урамшуулал	-	26,672,098.00
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр тэтгэмж	-	14,772,468.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн тэтгэмж	28,098,682.00	25,399,380.00
	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	167,797,923.50	16,921,680.20
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	167,797,923.50	16,921,680.20
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III=(I-II))	37,599,378.20	41,268,861.90
	Хөрөнгө оруулалтын мөнгөн орлогын Дүн IV)	-	-
	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРЛАГЫН ДҮН (V)	37,599,000.00	41,269,240.00
	Биет ба биет бус хөрөнгө худалдаж авсан зардал	37,599,000.00	41,269,240.00
	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ VI=(IV-V)	(37,599,000.00)	(41,269,240.00)
	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ VII	-	-
	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ ДҮН (VIII)	-	-
	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН (IX)=(VII)+(VIII)	378.20	(378.10)
	Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	378.10
	Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ

УС ЦАГ УУР, ОРЧНЫ СУДАЛГАА МЭДЭЭЛЛИЙН ХҮРЭЭЛЭН
АУДИТ ХИЙГДСЭН ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН
 2017 оны 12-р сарын 31-нээр дуусвар болсон тайлант жил

ҮЗҮҮЛЭЛТ					/төгрөг/
	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	
2015 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	-	-	757,946,684.75	757,946,684.75	
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт			-	-	
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-	20,702,308.19	20,702,308.19	
Тайлант үеийн үр дүн			20,702,308.19	20,702,308.19	
2016 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	-	-	778,648,992.94	778,648,992.94	
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				-	
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-				
Тайлант үеийн үр дүн					
2017 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	-				



**УС ЦАГ УУР, ОРЧНЫ СУДАЛГАА МЭДЭЭЛЛИЙН ХҮРЭЭЛЭН
АУДИТ ХИЙГДСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН
2017 оны 12-р сарын 31-нээр дуусвар болсон тайлант жил**

ҮЗҮҮЛЭЛТ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	/төгрөг/ Зөрүү	Хувь
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		378.10	(378.10)	
I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,172,123,500.00	1,156,567,834.20	15,555,665.80	98.7
УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	1,172,123,500.00	1,156,567,834.20	15,555,665.80	98.7
Бараа, үйлчилгээний зардал	1,100,279,600.00	1,099,574,676.00	704,924.00	99.9
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	947,047,700.00	946,381,117.00	666,583.00	99.9
Үндсэн цалин	800,854,100.00	800,187,517.00	666,583.00	99.9
Нэмэгдэл, урамшил	107,369,800.00	107,369,800.00	-	100.0
Унаа, болон бусад нөхөн олговор	38,823,800.00	38,823,800.00	-	100.0
Нийгмийн даатгалын шимтгэл	104,175,300.00	104,175,300.00	-	100.0
Тэтгэврийн даатгал	71,958,596.00	71,958,596.00	-	100.0
Тэтгэмжийн даатгал	6,443,343.00	6,443,343.00	-	100.0
ҮОМШ өвчний даатгал	8,054,164.00	8,054,164.00	-	100.0
Ажилгүйдлийн даатгал	1,610,833.00	1,610,833.00	-	100.0
Байгууллага төлөх ЭМД-хураамж	16,108,364.00	16,108,364.00	-	100.0
Хангамж, бараа материалын зардал	18,900,200.00	18,899,999.00	201.00	100.0
Бичиг хэргийн зардал	4,019,200.00	4,376,310.00	(357,110.00)	108.9
Тээвэр (шатахуун)	7,278,800.00	6,920,000.00	358,800.00	95.1
Шуудан, холбоо	6,378,400.00	5,296,309.00	1,082,091.00	83.0
Бага үнэтэй түргэн элэгдэх зүйл	1,223,800.00	2,307,380.00	(1,083,580.00)	188.5
Норматив зардал	571,800.00	570,000.00	1,800.00	99.7
Норм хувцас зөөлөн эдлэл	571,800.00	570,000.00	1,800.00	99.7
Эд хогшил урсгалын зардал	12,988,300.00	12,987,800.00	500.00	100.0
Багаж, техник, хэрэгсэл	7,114,100.00	5,886,800.00	1,227,300.00	82.7
Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл	128,300.00	126,000.00	2,300.00	98.2
Урсгал засвар	5,745,900.00	6,975,000.00	(1,229,100.00)	121.4
Томилолт, зочны зардал	10,619,300.00	10,619,300.00	-	100.0
Дотоод албан томилолт	10,619,300.00	10,619,300.00	-	100.0
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр	5,977,000.00	5,941,160.00	35,840.00	99.4
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,445,300.00	2,423,560.00	21,740.00	99.1
Аудит, баталгаажуулалт зэрэглэл тогтоох зардал	1,633,500.00	1,633,500.00	-	100.0
Даатгалын үйлчилгээ	1,268,600.00	1,260,000.00	8,600.00	99.3
Тээврийн хэрэгслийн татвар	257,000.00	251,500.00	5,500.00	97.9
Тээврийн хэрэгслийн оношлогоо	19,800.00	19,800.00	-	100.0
Газрын төлбөр	352,800.00	352,800.00	-	100.0
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	71,843,900.00	56,993,158.20	14,850,741.80	79.3
Бусад урсгал шилжүүлэг	71,843,900.00	52,071,478.00	19,772,422.00	72.5
Тэтгэвэрт гарахад нь олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	42,443,900.00	25,399,380.00	17,044,520.00	59.8
Нэг удаагийн тэтгэмж урамшуулал	29,400,000.00	26,672,098.00	2,727,902.00	90.7
Олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	-	-	-
Төвлөрүүлэх шилжүүлэг	-	-	-	-
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,172,123,500.00	1,156,567,834.20	15,555,665.80	98.7
УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,170,473,500.00	1,154,621,396.00	15,852,104.00	98.6
Улсын төсвөөс санхүүжих	1,170,473,500.00	1,149,996,154.00	20,477,346.00	98.3
ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ	1,650,000.00	1,946,438.20	(296,438.20)	118.0

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
ЗӨРЧИЛГҮН
САЛАН ДҮНДЭН

АЖИЛЛАГААНААС

Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,650,000.00	1,650,000.00	-	100.0
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	378.10	(378.10)	
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-		-	
ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ			-	
БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1	-	100.0
АЖИЛЛАГСДЫН ТОО	98	98	-	100.0
Удирдах ажилтан	1	1	-	100.0
Гүйцэтгэх ажилтан	93	93	-	100.0
Үйлчлэх ажилтан	4	4	-	100.0
Төрийн үйлчилгээний бусад албан хаагч /ТҮ/	98	98	0	100.0

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

**ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ**

**УС ЦАГ УУР, ОРЧНЫ СУДАЛГАА МЭДЭЭЛЛИЙН ХҮРЭЭЛЭН
АУДИТ ХИЙГДСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН
2017 оны 12-р сарын 31-нээр дуусвар болсон тайлант жил**

ҮЗҮҮЛЭЛТ	Төлөвлөгөө	/ төгрөг/ Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		-	-	
I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	-	920,448,304.24	(920,448,304.24)	
УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	-	920,448,304.24	(920,448,304.24)	
Бараа, үйлчилгээний зардал	-	920,448,304.24	(920,448,304.24)	
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	-	474,177,209.00	(474,177,209.00)	
Үндсэн цалин		474,177,209.00	(474,177,209.00)	
Нийгмийн даатгалын шимтгэл	-	47,139,634.00	(47,139,634.00)	
Тэтгэврийн даатгал		47,139,634.00	(47,139,634.00)	
Байр ашиглалтай холбоотой тогтмол зардал		2,990,601.00	(2,990,601.00)	
Гэрэл цахилгаан		2,990,601.00	(2,990,601.00)	
Хангамж, бараа материалын зардал	-	38,490,299.00	(38,490,299.00)	
Бичиг хэргийн зардал		13,826,000.00	(13,826,000.00)	
Тээвэр (шатахуун)		13,482,000.00	(13,482,000.00)	
Шуудан, холбоо		2,229,000.00	(2,229,000.00)	
Бага үнэтэй түргэн элэгдэх зүйл		8,953,299.00	(8,953,299.00)	
Эд хогшил урсгалын зардал	-	91,333,405.00	(91,333,405.00)	
Багаж, техник, хэрэгсэл		46,797,555.00	(46,797,555.00)	
Тавилга		4,567,540.00	(4,567,540.00)	
Урсгал засвар		39,968,310.00	(39,968,310.00)	
Томилолт, зочны зардал	-	81,722,787.24	(81,722,787.24)	
Гадаад албан томилолт		37,403,774.00	(37,403,774.00)	
Дотоод албан томилолт		43,902,267.00	(43,902,267.00)	
Зочин төлөөлөгч хүлээн авах		416,746.24	(416,746.24)	
Бараа үйлчилгээний бусад зардал	-	172,594,369.00	(172,594,369.00)	
Бараа үйлчилгээний бусад зардал		172,594,369.00	(172,594,369.00)	
Төвлөрүүлэх шилжүүлэг		12,000,000.00	12,000,000.00	
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	-	920,448,304.24	(920,448,304.24)	
Нэмэлт санхүүжилтийн орлого	-	920,448,304.24	(920,448,304.24)	
Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж		862,968,304.24	(862,968,304.24)	
Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны		1,500,000.00	(1,500,000.00)	
Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт		55,980,000.00	(55,980,000.00)	
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-	-	
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-	-	
ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ				
БАЙГУУЛЛАГЫН ТОО				
АЖИЛЛАГСДЫН ТОО				
Удирдах ажилтан		98	98	100.0
Гүйцэтгэх ажилтан		1	1	100.0
Үйлчлэх ажилтан		93	93	100.0
Төрийн үйлчилгээний бусад албан хаагч /ТҮ/		4	4	100.0
		98	98	100.0

98	98	-	100.0
1	1	-	100.0
93	93	-	100.0
4	4	-	100.0
98	98	-	100.0

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
ЗӨРЧИЛГҮЙ
САНАА ДҮГНЭЛТ